

Хэвлэлийн эрх чөлөө 2010 онд



Х.НАРАНЖАРГАЛ
“ГЛОБ ИНТЕРНЭШНЛ” ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГА

Хэвлэл эрх чөлөө-2010



- Уэндхукийн тунхаглал-20 жил
- Дэлхийн хэвлэл эрх чөлөөний өдөр-20 жил
- Монголд чөлөөт хэвлэлийн тогтолцоо үүсч бий болсоны 20 жил

Уэндхукийн тунхаглал



- Хараат бус хэвлэл мэдээлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хувьд, мөн үйлдвэрлэл, түгээлттэй холбоотой материал, дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ
- Олон ургальч хэвлэл мэдээлэл гэж аливаа хэлбэрийн монополь алга болж, аль болох өргөн хүрээтэй санаа бодлыг илэрхийлдэг аль болох олон тооны сонин, сэтгүүл, тогтмол хэвлэлтэй байхыг хэлнэ.

2010 оны хэвлэлийн эрх чөлөөний өдөр



- НҮБ-ын ерөнхий нарийн бичгийн дарга Бан Ки-мүүн
- НҮБ-ын хүний эрхийн комиссар Нави Пиллей
- ЮНЕСКО-гийн ерөнхий захирал Ирина Бокова

ХАМТАРСАН ИЛГЭЭЛТ

Хамтарсан илгээлт



- Хэвлэл мэдээллийн салбар танигдахын аргагүй өөрчлөгдсөн ч зорилт хэвээр
- Мэдээлэл харилцааны шинэ технологи шинэ боломж олгосон. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зарчим адил үйлчилнэ
- Хуучин байсан хязгаарлалтын зэрэгцээ мэдээллийг шүүлтүүртэх, цагдан хянах, албадан зогсоох шинэ оролдлого
- Интернэт дэлхий даяар олон нийтийн мэдээллийн эх сурвалж болсон учир онлайн сэтгүүлчдийг хамгаалах
- Хэвлэл, агаарын долгион, онлайн талбарт үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжихийг засгийн газруудад уриалав

Шоронд хоригдсон сэтгүүлчид



Africa (28)

Burundi (1)
Egypt (1)
Eritrea (17)
Ethiopia (4)
Sudan (3)
The Gambia (1)
Tunisia (1)

Americas (4)

Cuba (4)

Asia (54)

Bangladesh (1)
Burma (13)
China (34)
Indonesia (1)
Vietnam (5)

Europe and Central Asia (15)

Azerbaijan (1)
Kazakhstan (1)
Kyrgyzstan (2)
Moldova (1)
Russia (1)
Turkey (4)
Uzbekistan (6)

The Middle East and North Africa (43)

Afghanistan (1) Syria (2)
Bahrain (2) Saudi Arabia (1)
Iran (34) Yemen (1)
Iraq (1)
Kuwait (1)

Амь эрсдсэн сэтгүүлчид




Хэвлэлийн эрх чөлөө- Freedom House




Хэвлэлийн эрх чөлөөний индекс-RSF



FREEDOM OF THE PRESS WORLDWIDE IN 2011



Интернэтийн чөлөөт байдал- Freedom House



Монгол Улсад



Эрх зүйн салбарт өөрчлөлт гарсан

- 188 хууль, 2010. 12.31
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх, эрх чөлөөний тухай хууль- УИХ
- Цахим гарын үсгийн тухай хууль- УИХ
- 2010-2015 онд хэрэгжүүлэх “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах Үндэсний хөтөлбөр”. Засгийн газрын 2010 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн 141 тогтоолоор батлагдсан.
- “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”. УИХ-ын 2010 оны 7-р сарын 15-ны өдрийн 48 тогтоолоор шинэчлэн баталсан.
“Мэдээллийн аюулгүй байдал”-ыг хангах тусгай бүлэг

Хэвлэл мэдээллийн эрх зүй



- “Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр
- “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”,
- “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл, шаардлага”

Шинэ зохицуулалт



- Өмчлөлийн ил тод байдал
- Олон нийтийн үйлчилгээний үүрэг
- Агуулгад тавигдах шаардлага
- Өөрийн бүтээлийн шаардлага
- Цахим хуудасны бүртгэл-3000
- Тусгай зөвшөөрлийн хүрээ
- Зар сурталчилгааны хязгаарлалт
- Орлого хуваарилах зарчим
- Өөрийн тогтолцоо

Эрх зүйн чиг хандлага



- Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хуулийн төсөл
- Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн хувилбар
- Кибер орчны аюугүй байдлын тухай хууль
- Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн төсөл
- Өгөгдлийн сан хамгаалах тухай хуулийн төсөл

Мэргэжлийн эрхийн зөрчил-30



- Эрүүгийн хэрэгт буруутгасан 5
- Иргэний хэрэг 5
- Ажлын багаж хэрэгсэл хураан авсан 2
- Айлган сүрдүүлсэн 10
- Нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан 6
- Редакцийн цензур 2

75 хувь - эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч

Мэргэжлийн эрхийн зөрчил



Зөрчлийн хэлбэр	2006	2007	2008	2009	2010	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	-	-	12
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	13	10	59
Мэдээлэл өгөхөөс татгалзсан	8	10	13	2	-	33
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2	-	2	8
Шүүх, цагдаа, төрийн байгууллагын байгууллагын дарамт	2	8	5	3	5	18
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	1	6	10
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур.	2	1	3	1	2	7
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	0	5	10
Нийт	41	37	59	20	30	187

Интернэт- 2005.12.21



- НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч Эмбей Лигабо
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч Миклос Харазти
- Америкийн муж улсуудын байгууллагын үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч Эдуардо Бертони

ХАМТАРСАН ТУНХАГЛАЛ

Хамтарсан тунхаглал



Интернэт үйлчилгээний нийлүүлэлт, цахим хуудас, блог буюу мэдээлэл түгээлтийн онлайн систем, түүнчлэн Интернэт өргөн нэвтрүүлэг ажиллуулахын тулд бүртгүүлэх, төрийн аливаа байгууллагаас зөвшөөрөл авах ёсгүй. Энэ нь зөвхөн техникийн зориулалтаар домэйн нэрийн эрхийн бүртгэл, эсвэл арилжааны аливаа хэлбэрт хамааралтай ерөнхий хэрэглээний дүрэм журамд хамаарахгүй.

Хамтарсан тунхаглал



Хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн хэвлэл мэдээллийн салбарт засгийн газар, улс төр, арилжааны нөлөөнөөс хамгаалагдах эрх чөлөө нь дэлхий нийтэд нэгэнт хүлээн зөвшөөрөгдсөний нэгэн адил олон улсын болон үндэсний хэмжээнд интернэтийг дээрх нөлөөллөөс хараат бус байгууллагууд хянах ёстой. Интернэтийн домэйн нэрийг зохицуулах дотоодын дүрэм журам нь агуулагыг нь хянах хэрэгсэл хэзээ ч болох ёсгүй.

Хамтарсан тунхаглал



Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүлээн зөвшөөрснөөр интернэтэд холбогдох боломжийг, түүний дотор улсын мэдлийн сүлжээгээр дамжин холбогдох боломжийг, хангах зориулалтад зохих хөрөнгө нөөц гаргах үүргийг нийт улс гүрэн хүлээнэ. бүх нийтийн хүртээмжийг хөхиүлэн дэмжих хангалттай боломж бүрдүүлэх үүрэг хүлээлгэдэг. Ядуу буурай улс орнуудад тэдгээрийн үүргээ гүйцэтгэхэд нь олон улсын хамтын нийгэмлэг тусламжийн хөтөлбөрүүдийн хүрээнд энэхүү чиглэлд тэргүүн ач холбогдол өгөх ёстой.

Хамтарсан тунхаглал



Засгийн газар буюу аливаа арилжааны үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон, эцсийн хэрэглэгч хянах боломжгүй шүүлтийн системүүд нь цензурын өмнөх хэлбэр бөгөөд үүнийг зөвтгөх үндэслэлгүй юм. Эцсийн хэрэглэгчдэд зориулагдсан шүүлтийн системийн бүтээгдэхүүн нь ажиллах заавар, хэт шүүлтээс үүдэлтэй оюун санааны урхийн талаар тодорхой мэдээлэл олгосон нөхцөлд түгээгдэнэ.

Хамтарсан тунхаглал



Интернетэд тавьсан аливаа мэдээллийн зохиогч, эсвэл өөрийн болгон тавьсан хүн буюу тэрхүү мэдээллийг Интернетээс авах тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс татгалзсан этгээдээс бусад аливаа этгээд Интернет дэх мэдээллийн агуулгын талаар хариуцлага хүлээх ёсгүй. Интернетийн контентэд хамаарах хууль тогтоомж нь зөвхөн албан ёсоор тогтоогдсон зохиогч, буюу утга агуулга нь тусгайлан хамаарах улс орны хүрээгээр хязгаарлагдах бөгөөд мэдээллийг аливаа оронд татан авсан гэдгээр нь хуулийн хариуцлагад татаж болохгүй.

Хамтарсан тунхаглал



Интернетээр түгээж буй аль эсвэл хүлээн авч буй мэдээлэлийн хязгаарлалтыг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаатай нарийн уялдаа холбоотой, интернэтийн онцлогийг харгалзан тогтоох ёстой.

Хамтарсан тунхаглал



Интернэт хайлт, чат, хэвлэн нийтлэл болон бусад үйлчилгээ эрхэлдэг байгууллагууд өөрсдийн үйлчлүүлэгчдийн Интернэтийг гадны нөлөөгүй ашиглах эрхийг нь хүндэтгэх талаар баталгаа гаргах ёстой. Зарим улс оронд үйл ажиллагаа явуулахтай холбоотой бэрхшээл учрах үед, эдгээр байгууллагуудыг бусад оролцогчдын дэмжлэгтэйгээр энд бичигдсэн зарчмуудын эсрэг интернэтийн хэрэглээг хянах, эсвэл хязгаарлах албан ёсны оролдлогуудыг эсэргүүцэх үйл хэрэгт хамтран ажиллахыг сайшаана.

Мониторингийн шинэ систем-ННФ

Зөрчлийн тухай мэдээ
хүлээн авах

- Шинэ вэб сайт: CMS (нээлттэй, хаалттай)
- И-мэйл
- Утас
- Мессеэж
- Захидал
- Мэдээлэл түгээх: дотоод, гадаадад

Үйлчилгээ:

- Эрхээ хамгаалах тухай мэдээлэл: уэб сайт
- Эрх нь зөрчигдсөн сэтгүүлчийг хамгаалах: эсэргүүцлийн захидал
- Хуулийн үнэгүй зөвлөгөө
- Өмгөөллийн үйлчилгээ
- Глобын мэдээ: онлайн сонин бичиг

Ил хэл эс бөгөөс эрх чөлөө чинь улам
хумигдана



- www.globeinter.org.mn/selfalerting
- alert-mon@yahoo.com
- **32 47 64, 32 46 27**
- **99127127, 99193327**

Дүгнэлт



- Редакцийн эд хөрөнгөд халдсан нь ноцтой
- Шүүх, цагдаа, зохицуулах байгууллагын дарамт өсөх төлөвтэй
- Редакцийн цензур улам гүнзгийрч, шинж чанар нь ноцтой болж байна
- Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлчийн эсрэг ашиглах нь нэмэгдэж байна
- Нэхэмжлэл, торгуулийн хэмжээ нэмэгдэж буй нь эдийн засгийн цензур болон хувирч болзошгүй
- Өөрийн цензур улам их болж байна



Баярлалаа